

ДЭЭВЭР ЗАСВАРЫН АЖИЛ (СХД) АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
ДААЛГАВАР

2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

№2023/151

Улаанбаатар хот


1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/1415 дугаар захирамж.
2	Барилга байгууламжийн байршил	- 23 дугаар хорооны цогцолбор байрны дээвэр - 38 дугаар хороо, 22 дугаар байрны дээвэр
3	Зориулалт, хүчин чадал	- барилгын дээврийн засвар
4	Барилгын үндсэн бүтээц, материал	- Төслөөр
5	Төслийн бүрдэл иж	<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Тайлбар бичиг - Ажлын тоо хэмжээ - Магадлалын дүгнэлт /хавсралт дүгнэлтийн хамт/ <u>Зураг төсвийн иж бүрдэл:</u> - Одоогийн байдал /фото зургаар баталгаажуулах/ - Хэмжилтийн зураг - Өөрчлөлтийн ажлын зураг /Магадлалаар батлагдсан байх/ - Барилгын нэгдсэн төсөв /Магадлалаар батлагдсан байх/
6	Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа	<u>Ажлын зураг төсөв нэг үе шаттай:</u> - Ажлын зураг төсөв боловсруулж, зөвшилцөж батлуулах. - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
7	Зураг төслийн байгууллага	Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага
8	Төслийн захиалагч	- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
9	Засвар ажлууд хийгдэх	<u>Дээвэр хуулж, буулгах, шинээр хийх</u> - Хуучирч муудсан дээврийг хуулж, буулгах - Хөрсжүүлэлт, ус тусгаарлах ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын стандартад нийцсэн материалаар, угсралтын техникийн дагуу гүйцэтгэх. - Дээврийн налууг стандартын дагуу шинээр гаргах. - Парапетны эвдэрч муудсан хэсгийг засварлах, шаардлагатай тохиолдолд шинээр хийх. - Усны хаяглагыг стандартын дагуу хийх. хог шүүгч шинээр хийх. - Парапет болон дээврийн ус тусгаарлах материалын уулзварыг ус нэвчихээргүйгээр гүйцэтгэх. - Дээврийн засварын ажилтай холбоотой даган гаргах бусад засварын ажлууд хийж гүйцэтгэх. - Агааржуулалтын хоолойн өрлөгийг засварлах. - Орцноос дээвэр лүү гарах нээлхийний таг засварлах - Агааржуулалтын хоолой, тагны нурж, эвдэрсэн хэсгийг засварлах шаардлагатай тохиолдолд шинэчлэх.

10	Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага; <p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Барилгын тухай хууль <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Дээврийн ажил БНБД 31-07-05 - Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 - Дээвэр болон барилга байгууламжид хэрэглэх ус, уур тусгаарлах хуйлмал материал MNS 6303-2016 - Ус үл нэвтрүүлэх хуйлмал материал ТУ 5774-002-12157915-98 - Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02 - Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12 - Бусад холбогдох норм, дүрэм; <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000 - Ажлын байрны бичил цаг уурийн эрүүл ахуйн хэмжээ MNS 12.013-91 - Бусад холбогдох стандартууд:
11	Онцгой нөхцөл	<p><u>Засварын ажилд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> - Засварын ажилд ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн. Монгол Улсын стандартад нийцсэн материал байх. - Даацын бүтээцэд өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж, ажлын зураг зурах - Ажил эхлэх үед холбогдох хүмүүст мэдэгдэж хийгдэх ажлын дараалал, хугацааг тодорхой болгож мэдээллэнэ. - Тендерт ирүүлэх төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах.
12	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 21-01-02
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

 /Б.ЛХАГВАЖАВ/

 /Э.БАТЦЭНГЭЛ/